


Батлав. "ДЦС-4" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал


Б. ГАНХУЯГ
УОМГ 117 2688352

Батлав. ШУТИС, ЭХС-ийн захирал. "Эрчим хүч
& engineering" сэтгүүлийн эрхлэгч


Проф. Ч. МАНГАЛЖАЛАВ
УТӨС 012 9087087
УЛААНБААТАР ХОТ

"Эрчим хүч & engineering" сэтгүүлийг захналах тухай гэрээ

2020 оны 12 сарын 08 өдөр
2020.0104

№ 4/2021-01

Улаанбаатар хот

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас "ДЦС-4" ТӨХК /цаашид захиалагч гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий инженер Б.Ганхуяг, нөгөө талаас ШУТИС: ЭХС-ийн "Эрчим хүч & engineering" Сэтгүүл /цаашид сэтгүүл гэх/, түүнийг төлөөлж сэтгүүлийн ерөнхий редактор Х.Энхжаргал нар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Тус гэрээний зорилго нь ШУТИС:ЭХС-ийн эрхлэн гаргадаг "Эрчим хүч & engineering" сэтгүүлийн захиалагч талын захиалгатай холбогдсон харилцааг зохицуулна.

2. СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Төлбөрийг гэрээний 4.2, 4.3, 4.4-т зааснаар шаардан авах эрхтэй.
- 2.2 Захиалагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд сэтгүүл гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 2.3 Захиалагчийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг захиалагчийн зөвшөөрсний дагуу хэвлэн нийтлэх эрхтэй.
- 2.4 Сэтгүүл нь Монгол крилл үсгээр бэлтгэгдэж, улиралд 3 (гурван) дугаар буюу жилд 12/арван хоёр/ дугаар хэвлэгдэх ба дугаар тус бүрээс 100 /Нэг зуу/-н ширхгийг хүргэх үүрэгтэй.
- 2.5 Сэтгүүлийг хэвлэлийн чанар, дизайн, өнгө үзэмжийн өндөр түвшинд бэлтгэн хэвлэх эрхтэй.
- 2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс захиалагчид учруулсан хохирол, зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

3. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Захиалагч нь сэтгүүлийн захиалгын төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.
- 3.2 Захиалагч энэхүү гэрээний 2.4, 2.5, 2.6-д зааснаар үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.3 Сэтгүүл нь эрчим хүчний салбарын хурал зөвлөгөөнийг 2 /хоёр/ жилд нэг удаа зохион байгуулж болох бөгөөд захиалагч оролцох эрхтэй.
- 3.4 Захиалагч гэрээгээр тохиролцсоны дагуу сэтгүүлийг гэрээний хугацаанд сэтгүүл хэвлэлтээс гарсан даруйд хүлээн авах эрхтэй.
- 3.5 Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй бол захиалагч үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.6 Захиалагч нь сэтгүүлд өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хүргүүлэх эрхтэй.
- 3.7 Захиалагч нь захиалсан сэтгүүлээ тоогоор нь буюу хугацаанд нь хүлээн аваагүй бол шилжүүлсэн төлбөрөө буцаан нэхэмжлэх эрхтэй.

4. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА БА ТӨЛБӨР

- 4.1 Энэхүү гэрээг 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулав.
- 4.2 Гэрээний дагуу сэтгүүлийн нэг удаагийн /сараар/ захиалгын үнэ 800000 /Найман зуун мянган төгрөг/ байна.
- 4.3 Гэрээний нийт үнэ буюу сэтгүүл захиалгын нийт /12 сараар/ үнийн төлбөр 9600000 /Есөн сая зургаан зуун мянган төгрөг/ байна.
- 4.4 Гэрээт ажлын төлбөрийн нийт үнийн дүнг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдөрт **Голомт** банкны **8115101743** тоот, **ШУТИС ЭХС** нэртэй төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 4.5 Гэрээний хугацаанд гэрээнд заасан үнэ өөрчлөгдөхгүй

5. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээнд талууд эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хууль зүйн хувь адил 2 хувийг үйлдэх ба 1 хувийг захиалагч тал, 1 хувийг гүйцэтгэгч талууд хадгална.
- 5.2. Энэхүү гэрээнээс үүсэх аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


“ДЦС-4” ТӨХК-ний Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер


Б.ГАНХУЯГ

ТЭЭХ-ийн дарга


Ж.ОТГОН

СБХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч


Д.ТӨМӨРТОГОО


ХААХ-ийн дарга


В.ЛХАГВАДОРЖ

Хуулийн зөвлөх


Ч.БЯМБАСҮРЭН

Гэрээний мэргэжилтэн


С.ДОНИД

“Эрчим хүч & engineering”

Сэтгүүлийн ерөнхий редактор


Академич Х.ЭНХЖАРГАЛ

Хаяг: СБД, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Эрчим Хүчний сургууль, ШУТИС-ийн хоёрдугаар байр, 510 тоот

Email: am.za36@yahoo.com

Утас: 80405500, 99119896

Факс: 323579